

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,  
2018 оны 4-р сарын 11-ний байдлаар


2018 оны 4-р сарын 11-ний байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 4.7 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.2 хувиар өссөн байна.

**Махны дундаж үнэ:** 2018 оны 4-р сарын 11-ний байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 9.9 хувь, үхрийн ястай махны үнэ 6.1 хувь, үхрийн цул махны үнэ 4.8 хувь, адууны ястай махны үнэ 7.6 хувь, ямааны махны үнэ 18.1 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.3 хувиар өссөн бол бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 4-р сарын 11-ний байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7180 төгрөг, үхрийн /ястай/ мах 8200 төгрөг, үхрийн цул мах 9720 төгрөг, адууны /ястай/ мах 6075 төгрөг, ямааны /ястай/ мах 5535 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




**Гурилын үнэ:** 2018 оны 4-р сарын 11-ний байдлаар савласан дээд гурилын үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногтой харьцуулахад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2018 оны 4-р сарын 11-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

**Зураг 2.** Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2018 оны 4-р сарын 11-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 7.9 хувь, луувангийн үнэ 8.2 хувь, байцааны үнэ 10.9 хувь, хүрэн манжингийн үнэ 27.6 хувь, сонгины үнэ 4.6 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос байцааны үнэ 5.4 хувиар өсөж бусад хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

**Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ:** 2018 оны 4-р сарын 11-ний байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 2.5 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 1.3 хувиар өссөн бол задгай сүүний үнэ өөрчлөлтгүй байлаа. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байгаа бол цөцгийн тосны үнэ өмнөх сараас 4.9 хувь, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байлаа.